

өдөр тутмын хэрэглээний
хятад хэл



每日汉语

蒙古语 06



国家汉办/孔子学院总部
Hanban/Confucius Institute Headquarters



中国国际广播电台
CHINA RADIO INTERNATIONAL



中国国际广播出版社

өдөр тутмын хэрэглээний
хятад хэл

每日汉语

图书在版编目 (CIP) 数据

每日汉语·蒙古语/《每日汉语》编写组编著. —北京:

中国国际广播出版社, 2009.12

ISBN 978-7-5078-3123-8

I. 每… II. 每… III. 汉语-对外汉语教学-教材

IV. H195.4

中国版本图书馆CIP数据核字 (2009) 第182071号

出 版 人	马连弟
监 制	李晓琤
统 筹	郑凤杰
美术设计	田荣荣
插 图	三 柏
审 定	斯 勤
责任编辑	马冬冬
特邀编辑	诺敏娜日苏
责任校对	徐秀英
特邀校对	孟 和 (蒙古国)

每日汉语·蒙古语

中国国际广播出版社 (83139469 83139489 [传真]) 出版发行

北京复兴门外大街2号 (国家广电总局内) 邮编: 100866

www.chirp.com.cn

新华书店经销

环球印刷 (北京) 有限公司印刷

700×1000 1/32开本 25.5印张 400千字

2009年12月北京第一版 2009年12月第一次印刷

书号 ISBN 978-7-5078-3123-8/G·318 定价: 150.00元 (全6册)

国际广播版图书 版权所有 盗版必究

(如果发现印装质量问题, 本社负责调换)



目录 / гарчиг

第 58 课	在酒吧	
58-р хичээл	Бааранд	1
第 59 课	在迪斯科厅	
59-р хичээл	Диско бааранд	12
第 60 课	在电影院	
60-р хичээл	Кино театрт	23
第 61 课	在卡拉 OK	
61-р хичээл	Караокэд	35
第 62 课	看演出	
62-р хичээл	Тоглолт үзэх	46
第 63 课	看京剧	
63-р хичээл	Бээжин ший үзэх	59
第 64 课	在博物馆	
64-р хичээл	Музейд	70



目录 / гарчиг

第 65 课 晨练

65-р хичээл Өглөөний дасгал 80

第 66 课 健康与锻炼

66-р хичээл Эрүүл мэнд болон биеэ
дасгалжуулах 91

第 67 课 看比赛


67-р хичээл Уралдаан тэмцээн сонирхох 102

第 68 课 爬山与跑步

68-р хичээл Ууланд авирах болон гүйх 113

第 58 课 在酒吧

58-р хичээл Бааранд



Н: Сайн байцгаана уу? Эрхэм найз нараа. “Өдөр тутмын хэрэглээний Хятад хэл”-ээ сурцгаая. Номиннарс та бүхэнтэй мэндчилж байна.

М: Сайн байцгаана уу? Мөнхөө тантай мэндчилж байна.

Н: Өмнөх хичээлээр бид нэрээ бүртгүүлэхтэй холбоотой хэл хэллэгүүд ярьж сурсан. Одоо гол өгүүлбэрүүдийг товчхоон давгъя. Нэгдүгээр өгүүлбэр: 我的汉语不好.

М: Миний хятад хэл тааруухан.

Н: 我听不懂.

М: Би сонсоод ойлгохгүй байна.

Н: 什么时候开学?

М: Хэзээ сургууль эхлэх вэ?

Н: 一个学期的学费是多少?

М: Хагас жилийн сургалтын төлбөр нь хэдэн юань юм бэ?

Н: Бид өмнөх хичээлээр сурсан зүйлээ давтлаа. Одоо бид өмнөх хичээлээр сурсан нэгтгэсэн ярианы дасгалыг сонсоцгооё.



完整对话 Нэгтгэсэн ярианы дасгал

对话一 Ярианы дасгал нэг

А: 您以前学过汉语吗? Та өмнө нь хятад хэл сурч

байсан уу?

В: 学过一点儿。我的汉语不好。Бага зэрэг сурсан。
Миний хятад хэл тааруухан.

А: 你说得挺好的。Чи дажгүй ярьж байна шүү.

对话二 Ярианы дасгал хоёр

А: 我听不懂。您会说英语吗? Би сонсоод ойлгохгүй байна. Та англиар ярьдаг уу?

В: 对不起, 我不会说英语。Уучлаарай. Би англиар ярьдаггүй.

对话三 Ярианы дасгал гурав

А: 什么时候开学? Сургууль хэзээ эхлэх вэ?

В: 9月1号。9-р сарын 1-ний өдөр эхлэнэ.

对话四 Ярианы дасгал дөрөв

А: 一个学期的学费是多少? Хагас жилийн сургалтын төлбөр нь ямар үнэтэй юм бол?

В: 一个学期一万。Хагас жилийн сургалтын төлбөр нь арван мянган юань.

М: Эрхэм найз нараа, сая бид нэгтгэсэн ярианы дасгалаа давтлаа. Залгаад өнөөдрийн хичээлээр сурах чухал өгүүлбэрүүдээ сурцгаая.



今日关键 Чухал өгүүлбэрүүд

Wǒ yào yī píng pí jiǔ.

我要一瓶啤酒。Би нэг шил шар айраг авъя.

Nǐ yào nǎ zhǒng pí jiǔ?

您要哪种啤酒? Та ямар шар айраг авах вэ?

Yào jiā bīng ma?

要加冰吗? Мөс хийх үү?

Yǒu méi yǒu tàn suān yīn liào.

有没有碳酸饮料。Хийжүүлсэн ундаа байна уу?

Н: Мөнхөө, бид өчнөөн удаан хугацаагаар хичээллээ. Одоо бааранд очвол ямар байна?

М: Тэгье, тэгье. Би бааранд орж суугаад, шар айраг авч уух гэвэл хятадаар юу гэж хэлэх юм бэ?

Н: Мөнхөө, үүнийг ингэж хэлдэг юм: 我要一瓶啤酒. Би нэг шил шар айраг авъя.

М: 我要一瓶啤酒.

Н: 我要, би авах.

М: 我要.

Н: 一瓶, нэг шил.

М: 一瓶.

Н: 啤酒, шар айраг.

M: 啤酒。

H: 我要一瓶啤酒。

M: Би нэг шил шар айраг авъя.

对话一 Ярианы дасгал нэг

A: 请问您喝点儿什么? Та юу уух вэ?

B: 我要一瓶啤酒。Би нэг шил шар айраг авъя.

A: 请稍等, 马上就来。Түр хүлээж байгаарай. Одоохон.

B: 谢谢。Баярлалаа.

H: Баарны үйлчлэгч өөрөөс чинь ямар шар айраг авах вэ? гэж асууна. Тухайлбал: 您要哪种啤酒.

M: 您要哪种啤酒.

H: 您 гэдэг нь 你, чи гэсний хүндэтгэл үг, та гэсэн утгатай.

M: 您.

H: 要, авах.

M: 要.

H: 哪种, ямар төрлийн.

M: 哪种.

H: 啤酒, шар айраг.

M: 啤酒.

H: 您要哪种啤酒?

M: Та ямар шар айраг авах вэ?

Н: 不, үгүй гэсэн үгүйсгэсэн утгатай үг.

М: 不。

Н: 不加, нэмэхгүй.

М: 不加。

Н: 冰, мөс.

М: 冰。

Н: 不加冰。

М: Мөс хийхгүй.

对话三 Ярианы дасгал гурав

А: 请问您喝点儿什么? Та юу уух юм бэ?

В: 我要一杯苏格兰威士忌。Би нэг хундага шотланд виски авъя.

А: 要加冰吗? Мөс хийх үү?

В: 不加冰。Мөс хийхгүй.

Н: Бааранд очсон болгон архи уудаггүй. Зарим хүн нь хийжүүлсэн ундаа л уудаг.

М: Тиймээ. Миний зарим найз ч ийм байдаг. Тэд маань тэгвэл баарны үйлчлэгчид хандаж юу гэж хэлэх нь зүйтэй вэ?

Н: Ингэж хэлж болно: 有没有碳酸饮料. Хийжүүлсэн ундаа байна уу? Үгүй юү?

М: 有没有碳酸饮料。

Н: 有没有 гэдэг нь тэр болгон хэрэглэгддэггүй өгүүлбэрийн бүтэц юм. Байна уу, үгүй юү гэсэн утгатай үг.

М: 有没有。

Н: 碳酸, хийжүүлсэн, бусад зөөлөн чанартай ундааг хэлж байна.

М: 碳酸。

Н: 饮料, ундаа.

М: 饮料。

Н: 碳酸饮料, хийжүүлсэн ундаа.

М: 碳酸饮料。

Н: 有没有碳酸饮料?

М: Хийжүүлсэн ундаа байна уу, үгүй юү?

对话四 Ярианы дасгал дөрөв

А: 有没有碳酸饮料? Хийжүүлсэн ундаа байна уу, үгүй юү?

В: 有, 您要哪种? Байна. Та ямрыг нь авах вэ?

А: 我要一瓶可乐。Би нэг кока кола авъя.

В: 好的, 请稍等。За. Түр хүлээж байгаарай.

Н: Одоо бид өнөөдрийн хичээлээр сурсан нэгтгэсэн ярианы дасгалыг сонсоцгооё.



完整对话 Нэгтгэсэн ярианы дасгал

对话一 Ярианы дасгал нэг

A: 请问您喝点儿什么? Та юу уух вэ?

B: 我要一瓶啤酒。Би нэг шил шар айраг авъя.

A: 请稍等, 马上就来。Түр хүлээж байгаарай. Одоохон.

B: 谢谢。Баярлалаа.

对话二 Ярианы дасгал хоёр

A: 您要哪种啤酒? Та ямар шар айраг авах вэ?

B: 我要瓶装的。Би шилтэйг авъя.

对话三 Ярианы дасгал гурав

A: 请问您喝点儿什么? Та юу уух вэ?

B: 我要一杯苏格兰威士忌。Би нэг хундага шотланд виски авъя.

A: 要加冰吗? Мөс хийх үү?

B: 不加冰。Мөс хийхгүй.

对话四 Ярианы дасгал дөрөв

A: 有没有碳酸饮料? Хийжүүлсэн ундаа байна уу? Үгүй юү?

B: 有, 您要哪种? Байна. Та ямрыг нь авах вэ?

A: 我要一瓶可乐。Би нэг кока кола авъя.

В: 好的, 请稍等。За. Түр хүлээж байгаарай.

М: Өнөөдрийн хичээл энд хүрээд өндөрлөж байна. Одоо Хятадын соёлын тухай танилцуулья.



Хятадын соёлын тухай

Өнгөрсөн зууны 90-ээд оноос эхэлж, “Баарны соёл” Хятадын томоохон хотуудад орж ирсэн гэдэг боловч хамрах газар нутаг нь явах тусмаа өргөжсөөр байгаа юм. “Баарны соёл” хөгжиж ирсэн нь нийт Хятадын эдийн засаг, нийгэм болон соёлын өөрчлөлт хувиралттай салшгүй холбоотой. Хятадын эдийн засаг хөгжсөн Бээжин, Шанхай болон Шэньжэнь зэрэг хотуудад баарны соёл нь нэн ч ирмүүн бадруун хөгжиж байна. Бээжингийн баарны төрөл нь бүр ч баялаг байж, Шанхайн баар нь нам жим байдгаараа хүний сэтгэл хорогдуулж, Шэньжэний баар нь гал халуун уур амьсгалтай байдгаараа хотын залуучуудын зугаа цэнгүүний тухтай газар болж байдаг аж.

Бээжин бол хамгийн олон баартай хот юм. Төрөл зүйл нь ч маш олон. Жишээлбэл: хаягдмал том автобусаар хийсэн “汽车酒吧 машины баар”, хөл бөмбөгтэй холбоотой “足球酒吧 хөл бөмбөгний баар”,

кино үзэж болдог “电影酒吧 кино баар”, урлагийн уран намбатай “艺术家酒吧 урлаг баар” гээд зөндөө олон байна. Онцлон дурдууштай нь усны хөвөөнд ургасан уд модны мөчир намааны сүүдэр номин цэнхэр усанд туссан Ши Ча хайгийн баарны гудамж нь устай, усан дундаа онгоцтой, гүүртэй, баартай. Энэ бүхэн нь өнө эртний түүх соёлтой Бээжин хотод шинэ өнгө үзэмж нэмэрлэсэн гэж хэлэхэд ерөөс илүүдэхгүй. За. Өнөөдрийн хичээлээ өндөрлөх дөхөж байна. Би мөн уламжлал ёсоор танд нэг асуулт үлдээе: “Би нэг шил шар айраг авъя.” гэдгийг Хятадаар юу гэж хэлэх вэ?

Энэ асуултын хариуг та mon@cri.com.cn гэсэн хаягаар бидэнд И-мейл бичиж ирүүлээрэй. Энэ хичээлийг дахин сонсохыг хүсвэл та <http://mongol.cri.cn> гэсэн хаягаар манай вэб сайтаар зочлоорой. “Өдөр тутмын хэрэглээний Хятад хэл”-ний хичээлээр уулзалт түр баяртай. 再见!

第 59 课 在迪斯科厅

59-р хичээл Диско бааранд

